

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2022.01.14

Дугаар 15

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелүүлэх хугацаа	Биелэлт
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах объектын зураг төсөв, ажлын даалгаврын төслийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусгаж, ЗДТГ-т ирүүлэх	ГХБХБГ-ын дарга К.Болат БЗА	I/13	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах объектын зураг, төсөв хийх ажлыг зохион байгуулж байна. Зураг хийх компаниудаас санал авч байгаа. 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусгаж, ЗДТГ-т ирүүлэх болно гэх биелэлтийг ирүүлжээ.
2	Эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааны талаарх бодит, зөв мэдээллийг орон нутгийн телевиз, радиогоор нэвтрүүлэх	ЭМГ-ын дарга Н.Сакен АНЭ-н дарга Х.Манчук	I/13	ЭМГ: Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар Дербес телевиз болон олон нийтийн радио, телевизээр ард иргэдэд сэрэмжлүүлэг хүргүүлэв.
3	Сумдын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах үүрэг чиглэл өгөх, аймгийн нэгдсэн эмнэлгийн ачааллыг бууруулах, зөв хуваарилах арга хэмжээ авах	ЭМГ-ын дарга Н.Сакен АНЭ-н дарга Х.Манчук	I/13	АНЭ: Хүүхдийн томуу, томуу төст өвчний тархалт нэмэгдэж байгаа тул хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг тухайд нь үзүүлэх, хүүхдийн эмнэлгийн хэвийн үйл ажиллагаа, ажлын ачааллыг жигд байлгах зорилгоор нэмэлтээр их эмч, сувилагч, үйлчлэгч нарыг дайчлан ажиллуулахаар Аймгийн нэгдсэн эмнэлгийн “Түр” дайчлан ажиллуулах тухай 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаартай тушаалыг гаргасан. Ачаалал бага тасаг, нэгжүүдээс нэмэлтээр 4 их эмч, 8 сувилагч, 8 үйлчлэгчийг 24 цагаар ээлжээр ажиллуулж байна.
4	Аймгийн аялал жуулчлалын маршрутын эх, сурталчилгааны шторк, гарын авлагын материалуудын эхийг бэлтгэж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	БОАЖГ-ын дарга Ш.Марат	I/13	Аймгийн аялал жуулчлалын маршрутын эх, гарын авлагын материалуудын эхийг бэлтгэж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулан танилцуулж, эхний хувилбарыг хэвлүүлэхээр шийдвэрлэв гэх биелэлтийг ирүүлжээ.
5	Мөсний баярыг зохион байгуулах төлөвлөгөөний төслийг боловсруулж аймгийн ЗДТГ-т ирүүлэх	БТСГ-ын дарга Х.Хайнар	I/13	2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Толбо нуурт зохион байгуулагдах “Мөнгөн өвөл-2022” бүх нийтийн арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тэмцээний төсөв болон зохион байгуулах ажлын хэсгийн захирамжийн төслийг аймгийн Засаг даргад албан бичгээр хүргүүлэв.

6	Өлгий сумын иргэдийн Коронавируст халдварын эсрэг 3 дугаар тунгийн дархлаажуулалтад хамрагдалтыг эрчимжүүлэх арга хэмжээ авах	ЭМГ-ын дарга Н.Сакен АНЭ-н дарга Х.Манчук МХГ-ын дарга Х.Бауыржан	I/13	Аймгийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүргийн дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох улсын байцаагчид хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, нийтийн үйлчилгээний 61 аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын Коронавируст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт 3 дугаар тунд хамрагдсан байдал шалгалт хийхэд: 61 аж ахуйн нэгжийн 577 ажилчдаас 274 буюу 47% нь хамрагдсан, 75 буюу 12% нь эрүүл мэндийн шалтгааны улмаас хамрагдаагүй, харин 239 ажилчид буюу 41% нь огт хамрагдаагүй байна. Коронавируст халдварын мутацилагдсан хувилбар, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэхийн тулд үйлчилгээний байгууллагын ажилтнуудыг Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт 3 дугаар тунгийн дархлаажуулалтад бүрэн хамрагдахыг уриалж, зөвлөгөө өгч ажиллав.
---	---	--	------	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР